Тайлант онд дараах хуулиуд шинэчлэгдэн баталж, мөрдсөн байна. Үүнд:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасны дагуу Бүрэн тогтох сумын засаг даргын тамгын газрын даргын 2017 оны А/04 тоот тушаалаар дотоод хяналтын нэгжийг байгуулсан байна.

Тайлант хугацаанд дотоод хяналт хариуцсан нэгж 2022 онд дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган хяналт шалгалт хийж, биелэлтийг гарган ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тус байгууллага нь аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тус Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зарим журам заавар шинэчлэгдсэн тул, бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлага тулгараад байна. Гэхдээ санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бүрэнтогтох сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл, төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ.

#### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бүрэнтогтох сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 139.0 сая төгрөгөөр буюу 11.8 хувиар өссөн байна.

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Дансны авлага	5.5	1.0	(4.5)
Бараа материал	45.7	131.0	85.4
Үндсэн хөрөнгө	1,072.4	1,130.8	58.4
Биет бус хөрөнгө	53.2	53.0	(0.3)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,176.8</b>	<b>1,315.8</b>	139.0
Дансны өглөг	49.4	48.8	(0.6)
<b>Эздийн өмч</b>	<b>655.3</b>	<b>655.3</b>	-
-төрийн	655.3	655.3	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	533.6	533.6	-
Хуримтлагдсан үр дүн	(61.5)	78.2	139.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,176.8</b>	<b>1,315.8</b>	139.0

Нийгмийн даатгалын хэлтсээс 0.8 сая төгрөгийн авлагатай байгаа ба харилцагч байгууллагатай тооцоо нийлж баталгаажуулсан байна. Нэмэлт санхүүжилтийн үлдэгдэл 0.15 сая төгрөг төвлөрүүлж авлага үүсгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 85.4 сая төгрөгөөр нэмэгдсэн. Сумын 90 жилийн ойн хандиваар 7.4 сая төгрөгийн материал авч аж ахуйн материал болон бусад хангамжийн материал дээр бүртгэсэн байна. Сумын орон нутгийн хөгжлийн сангаас 83.2 сая төгрөгийн өвс, 1.2 сая төгрөгийн сумын гэрэлтүүлгийн зураг төсөв шилжүүлэн авч бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 58.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 33.6 сая төгрөгөөр Бүрэнхаан багийн эрчим хүчний шугамд холбох ажил хийгдсэн байна.
- Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн 69.0 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна.
- Сумын 90 жилийн ойн хандиваар 18.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө авсан байна.
- Аймгийн орон нутгийн өмчийн газрын даргын тушаалаар 56.9 сая төгрөг
- Төсвийн хөрөнгөөр 5.1 сая төгрөгийн техник хэрэгсэл

Хуримтлагдсан үр дүн данс 139.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 711.8 сая төгрөгөөр төлөвлөж санал хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн саналаас 130.3 сая төгрөгөөр бууруулж орон нутгийн төсвөөс 581.5 сая төгрөгөөр баталсан байна. Бүрэнтогтох сумын ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 27-ны 11 дугаар тогтоолоор тус байгууллагын төсвийг 2.6 сая төгрөгөөр хасах, 36.7 сая төгрөгөөр нэмэх тодотгол хийж 615.3 сая төгрөг болгож тодотгон баталсан байна.

Тус газрын 2022 оны төсвийг 2021 оны төлөвлөгөө гүйцэтгэлтэй харьцуулбал дараах байдалтай байна. **Үүнд:**

Үзүүлэлт	2022 оны батлагдсан төсөв	2021 оны		Төлөвлөгөөтэй харьцуулсан дүн	Гүйцэтгэлтэй харьцуулсан дүн
		төлөвлөгөө	гүйцэтгэл		
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	615.3	473.1	464.2	142.2	151.1

**Хүснэгтээс харахад:** 2022 оны төсвийг батлахдаа 2021 оны төлөвлөгөөнөөс 142.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлээс 151.1 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 10 зориулалт арга хэмжээг санхүүжүүлэхээр 615.3 сая төгрөгийн төсөв баталсан. Орон нутгийн төсвөөс 53.1 хувь буюу 326.8 сая төгрөг, санхүүгийн дэмжлэгээс 30.3 хувь буюу 186.7 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр 4.2 хувь буюу 1.5 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 615.7 сая төгрөгийн эх үүсвэрийг хүлээн авч, 588.2 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 27.5 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Харин үндсэн үйл ажиллагааны орлогыг 0.4 сая төгрөгийг давуулан биелүүлж, давсан хэсгийг төсөв хэтрүүлэн зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах гэсэн заалтыг зөрчсөн, эрх ба үүрэг батламж мэдэгдэл хангахгүй байна.

**Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал**

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>70106</b>	<b>Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага</b>	<b>503.3</b>	<b>477.5</b>	<b>25.8</b>	<b>96.3</b>
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	346.4	336.2	10.2	97.0
80106	Баг хорооны үйл ажиллагаа зардал	52.3	50.7	1.5	97.0
80112	Нийтлэг үйлчилгээ	41.1	38.9	2.2	94.6
80305	Биеийн тамир уралдаан тэмцээн	1.5	1.5	0.0	100
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	4.0	4.0	0	100
80815	Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн	27.6	27.6	0.01	99.9
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	22.3	10.5	11.7	47.3
82801	Улсын баяр наадам	8.0	8.0	0.0	100
<b>70503</b>	<b>Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт</b>	<b>100.0</b>	<b>98.7</b>	<b>1.3</b>	<b>98.6</b>
80918	Бусад	100.0	98.7	1.3	98.6
<b>71413</b>	<b>Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх</b>	<b>12.0</b>	<b>12.0</b>	<b>0.0</b>	<b>100.0</b>
81701	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ	12.0	12.0	0.0	100
<b>НИЙТ</b>		<b>615.3</b>	<b>588.2</b>	<b>27.1</b>	<b>95.5</b>

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 588.2 сая төгрөг, үүнд 0.4 сая төгрөгийг хэтрүүлэн зарцуулсан зардлын дүн орсон буюу 95.7 хувьтай байна. Тайлант оны төсвийн үлдэгдэл 27.5

сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн ба энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7<sup>1</sup> дахь заалттай нийцэж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан нэмэлт орлого 6.6 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 49.8 сая төгрөгийг нэмэлт дансанд орлогоор хүлээн зөвшөөрсөн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дараах орлогууд орсон байна. Үүнд:

- Бүрэнтогтох сумын нутаг дэвсгэрт байрлах Нүүрстэйн уурхайгаас Хөвсгөл Дулааны станцад зарж борлуулсан нүүрсний орлого 32.7 сая төгрөг
- Хөвсгөл ус сувагаас төрөөс хариуцах цэвэр бохир усны хөнгөлөлтийн орлого 8.2 сая төгрөг
- Тендерийн орлого 0.56 сая төгрөг
- Нөөцийн өвс худалдан борлуулсан 8.3 сая төгрөг
- Статисткийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардал 4.6 сая төгрөг
- Биеийн тамир спортын газраас нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх арга хэмжээний шагналд 1.5 сая төгрөг
- Аймгийн ИТХ-аас хамтарсан багийн зардалд 0.5 сая төгрөгний орлого орсон байна.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 2.3 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжинд 52.1 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 1.8 сая төгрөгийг зарцуулж 0.1 сая төгрөгийг авлага үүсгэн нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд төвлөрүүлсэн байна.

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хянан үзэхэд Хөвсгөл ус сувгаас төрөөс хариуцах цэвэр бохир усны хөнгөлөлтийн орлого 8.2 сая төгрөг, тус сумын нутаг дэвсгэрт байрлах Нүүрстэйн уурхайгаас Хөвсгөл дулааны станцад нүүрс борлуулан 32.7 сая төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалттай нийцэхгүй байгаа бөгөөд эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

<sup>1</sup> Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ.

Энэхүү тайланд Бүрэнтогтох сумын Засаг даргын тамгын газрын батлагдсан төсвийн хүрээнд ажиллах, Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах 2 зөвлөмж, төсөв зориулалт бусаар зарцуулсан 40.9 сая төгрөгийн 1 албан шаардлага, Үндсэн хөрөнгө данс бүртгэлд бүртгэхтэй холбоотой 11.3 сая төгрөгийн залруулга хийсэн болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мөнх-Оргил гүйцэтгэж, хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3/50 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 554.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 11.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилолт, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчил илрээгүй болно. Үүнд:

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 3 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгаж байна.

Бүрэнтогтох сумын Засаг даргын тамгын газрын 2022 онд байршуулсан мэдээллийг түүвэрлэн хянаж үзэхэд:

1. Тайланд онд цалингийн зардлаас бусад 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогын мэдээлэл 18 удаагийн 413.1 сая төгрөг, зарлагын 7 удаагийн 72.7 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна. Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалттай нийцэхгүй байгаа ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд:**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн талаар авч үзэхэд зөрчил илрээгүй болно.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөвсгөл аймгийн орон Бүрэнтогтох сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар халаалтын зардлын 49.2 сая төгрөгийн өр төлбөрийн тооцооны үлдэгдэлтэй байна, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалт хэрэгжүүлээгүй, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар хүргүүлсэн 3 зөвлөмжийн биелэлт 54.2% хэрэгжилттэй байгаа нь өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйг харуулж байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	106.2	3	57.6	54.2
Нийт дүн	3	106.2	3	57.6	54.2

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал:

Дараагийн аудитаар давтан шалгах онцгой асуудал байхгүй байна.

### 5. Аудитын илрүүлэлт

Бүрэнтогтох сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 11.3 сая төгрөгийн залруулгыг аудитын хугацаанд хийлээ. Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хянан үзэхэд Хөвсгөл ус сувгаас төрөөс хариуцах цэвэр бохир усны хөнгөлөлтийн орлого 8.2 сая төгрөг, тус сумын нутаг дэвсгэрт байрлах Нүүрстэйн уурхайгаас Хөвсгөл дулааны станцад нүүрс борлуулан 32.7 сая төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч зарцуулсан зөрчилд албан шаардлага, Сумын Иргэдийн төлөөгчдийн хурлаар батлагдсан өөрийн орлогын төлөвлөгөө 1.5 сая төгрөг ба гүйцэтгэл 1.9 сая төгрөг 0.4 сая төгрөгийг давуулан биелүүлсэн байна. Давсан орлогыг зарцуулж батлагдсан төсвийг 0,4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, цалингийн зардлаас бусад 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогын мэдээлэл 18 удаагийн 413.1 сая төгрөг, зарлагын 7 удаагийн 72.7 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байгаа зөрчилд зөвлөмжийг хүргүүллээ.

#### Залруулсан алдаа

Бүрэнтогтох сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 11.3 сая төгрөгийн залруулгыг аудитын хугацаанд хийсэн болно. Үүнд: Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн үндсэн хөрөнгийг шилжүүлэн авч данс бүртгэлд тусгаагүй орхигдуулсан байсныг бүртгэлд тусгуулсан болно.

#### 5.1 Төлбөрийн акт

Бүрэнтогтох сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

#### 5.2 5.3 Албан шаардлага

Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хянан үзэхэд Хөвсгөл ус сувгаас төрөөс хариуцах цэвэр бохир усны хөнгөлөлтийн орлого 8.2 сая төгрөг, тус сумын нутаг дэвсгэрт байрлах Нүүрстэйн уурхайгаас Хөвсгөл дулааны станцад нүүрс борлуулан 32.7 сая төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалттай нийцэхгүй байгаа бөгөөд эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Төсөв, төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Сумын Иргэдийн төлөөгчдийн хурлаар батлагдсан өөрийн орлогын төлөвлөгөө 1.5 сая төгрөг ба гүйцэтгэл 1.9 сая төгрөг 0.4 сая төгрөгийг давуулан биелүүлсэн байна. Давсан орлогыг зарцуулж батлагдсан төсвийг 0,4 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах гэсэн заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 1.2 Өгсөн зөвлөмж:

Давсан орлогыг орон нутгийн ерөнхий орлогын дансанд бүрэн төвлөрүүлж, дараа оны төсвийн эх үүсвэр болгох

#### 2. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

##### 2.1 Илрүүлэлт:

Тайланд онд цалингийн зардлаас бусад 5 саяас дээш үнийн дүн бүхий орлогын мэдээлэл 18 удаагийн 413.1 сая төгрөг, зарлагын 7 удаагийн 72.7 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна. Эдгээр нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалттай нийцэхгүй байгаа ба нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### 2.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг хууль журамд заасан хугацаанд бүрэн мэдээлж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Данс бүртгэлд бүртгээгүй	1	11.3	1	11.3			1	11.3				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>11.3</b>	<b>1</b>	<b>11.3</b>			<b>1</b>	<b>11.3</b>				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсөв хэтрүүлэн зарцуулсан	1	0.4					1	0.4					
Төсөв зориулалт бусаар зарцуулсан	1	40.9			1	40.9							
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>41.3</b>			<b>1</b>	<b>40.9</b>	<b>1</b>	<b>0.4</b>					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Мэдээлэл оруулаагүй.	1	485.8						1	485.8
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>485.8</b>						<b>1</b>	<b>485.8</b>

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

ГҮЙЦЭТГЭСЭН:

АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Б.ДАВААНЯМ ОГНОО:

Л.МӨНХ-ОРГИЛ





## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 24 өдөр

№ 23/А2260439/ХАА-2023/56  
НА - СТА - ТЦЗ

Мөрөн сум

### Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хянан үзэхэд Хөвсгөл ус сувгаас төрөөс хариуцах цэвэр бохир усны хөнгөлөлтийн орлого 8,178,400 (Найман сая нэг зуун далан найман мянга дөрвөн зуун) төгрөг, тус сумын нутаг дэвсгэрт байрлах Нүүрстэйн уурхайгаас Хөвсгөл дулааны станцад нүүрс борлуулан 32,723,200 (гучин хоёр сая долоон зуун хорин гурван мянга хоёр зуун) төгрөгийн орлогыг тус тус нэмэлт санхүүжилтийн дансанд хүлээн авч зарцуулсан зөрчил илэрлээ.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт "Төсвийн захирагч нь дараах нэмэлт төсвийг холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулж болно:"- тай нийцэхгүй байгаа бөгөөд эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тоот тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн

#### ШААРДАХ нь:

1. Аудитаар илэрсэн зөрчлийг таслан зогсоож, цаашид нэмэлт санхүүжилтийн дансанд байгууллагын үндсэн чиг үүрэгт хамааралгүй ажил үйлчилгээний орлогыг хүлээн авч зарцуулахгүй байх, хуулиар хүлээн зөвшөөрөгдсөнөөс бусад орлогыг Орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлж, дараа жилийн төсөвт батлуулан үр ашигтай, хөрөнгө оруулалтын шинж чанартай арга хэмжээнд зарцуулах
2. Албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 10-ны дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Бүрэнтогтох сумын Засаг даргын тамгын газрын дарга Х.Ганболд, нягтлан бодогч Г.Ундармаа нарт даалгав.

#### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР:

Л.МӨНХ-ОРГИЛ

<sup>1</sup>Хөвсгөл аймаг, Мөрөн сум 8-р баг, Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот Утас: 70384043